

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

АУДИТЫН КОД: /ГСА-2022/16-6-ШТА-ГА/

Говьсүмбэр аймаг
2022 оны 4 сар

Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа

Утас: 7054-3156 Цахим шуудан: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер Г.Наранбаяр

Утас: 7054-3179 Цахим шуудан: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Дарханбат

Утас: 7054-3179 Цахим шуудан: Darkhanbatb@audit.gov.mn

Аудитор С.Батцэцэг

Утас: 7054-3179 Цахим шуудан: BattsetsegSa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар	Бүлэг-1: Хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөөгүйгээс хуулийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ батлагдсаар байна.
Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа	А.1. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, төслийн бэлэн байдал зэрэгт үнэлгээ хийхгүйгээр төлөвлөлт хийсээр байна. 7
Аудитын менежер Г.Наранбаяр	А.2 Барилга байгууламжийн зураг төслийг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн байна..... 8 А.3 Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилт хангалтгүй байна. 8
Ахлах аудитор Б.Дарханбат Аудитор С.Батцэцэг	Бүлэг-2: Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт үр нөлөөгүй, хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг ашиглахгүй байгаа нь төсвийн хөрөнгө үр дүнгүй зарцуулагдаж байгааг харуулж байна. Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд жил бүр гомдол санал гарсаар байна. 10
2021 оны 04 дүгээр сар	Б.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг хангуулах тал дээр үр дүнтэй ажиллаж чадаагүй байна. 11
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70543151 дугаарын утсаар харилцана уу.	Б.3 Хяналтын тогтолцоо оновчгүйгээс төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналт үр дүнгүй байна..... 12 Б.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор Засгийн газраас гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй байна..... 14 Б.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцохгүй байна..... 14
ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 дугаар давхар, 209 тоот	Дүгнэлт Зөвлөмж Холбогдох байгууллагын санал Холбогдох байгууллагын саналд хийсэн тайлбар Хавсралтууд

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БСШУСС	Боловсрол соёл, шинжлэх ухаан спортын сайд
БОАЖС	Байгаль орчин аялал жуулчлалын сайд
БХБС	Барилга хот байгуулалтын сайд
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗТХС	Зам тээврийн, хөгжлийн сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СС	Соёлын сайд
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын их хурал
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХЗДХС	Хууль зүй дотоод хэргийн сайд
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ХХААХҮС	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШС	Шадар сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭХС	Эрчим хүчний сайд

Улсын төсвийн 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
<i>Хүснэгт 1</i>	Говьсүмбэр аймгийн ТЕЗ-аас Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд тусгаж хэрэгжүүлэхээр санал хүргүүлсэн төсөл, арга хэмжээ	7
<i>Хүснэгт 2</i>	Төсвийн тухай хуулиар тухайн жилд санхүүжүүлж байгаа төсөл арга хэмжээний санхүүжилтийн дүн	9
<i>Хүснэгт 3</i>	Эрх шилжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	11
<i>Хүснэгт 4</i>	Зохиогчийн хяналт хэрэгжүүлж буй байгууллага, төсөл арга хэмжээ	11
<i>Хүснэгт 5</i>	Эрх шилжсэн төсөл, арга хэмжээнд олгосон санхүүжилт	13
<i>Хүснэгт 6</i>	Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн боловч ашиглалтгүй байгаа хөрөнгө оруулалтын ажлын жагсаалт	15

Дүрслэлийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
<i>График 1</i>	Барьцаа хөрөнгөнд байршуулсан санхүүжилт	14
<i>Диаграмм 2</i>	Хэрэгжиж буй төсөл арга хэмжээг салбараар ангилсан диаграмм	16

Хавсралтын товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
<i>Хавсралт 1</i>	Орон нутгийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт	21
<i>Хавсралт 2</i>	Зураг төслийн гүйцэтгэгч байгууллагуудын тусгай зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацаа	22
<i>Хавсралт 3</i>	Зохиогчийн хяналтын гэрээний дүн, гүйцэтгэл	23
<i>Хавсралт 4</i>	Захиалагчийн хяналтын гэрээний дүн, гүйцэтгэл	24

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны “Аудитын төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу хийлээ.
Аудитын зорилт	Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймагт эрх шилжиж хэрэгжсэн “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Аудитын зорилтыг хангахын тулд дараах зорилт чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: ➤ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо үр нөлөөтэй байна уу? ➤ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байна уу?
Аудитын хамарсан хүрээ	Аудитад улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэхээр баталсан 9 төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд болон төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нарын үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны 69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, аудитор С.Батцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ
Хүндрэл бэрхшээл	Бусад аудиттай аудитын хугацаа давхардаж хүний нөөцийн дутагдал үүссэн нь аудитад хүндрэл учруулж байлаа.
Үндсэн мэдээлэл	Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд Говьсүмбэр аймагт 9 төсөл, арга хэмжээнд 23.1 тэрбум төгрөг батлагдсанаас тайлант хугацаанд 8.6 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр тусгасан ба 2 хөрөнгө оруулалтын ажил, 1 төсөл, арга хэмжээ шинээр батлагдаж, өмнөх оноос 6 төсөл, арга хэмжээ он дамжсан байна. Хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг салбараар нь ангилж үзвэл боловсрол, соёлын салбарт нийт төсөвт өртгийн 54.1 хувь буюу 12.5 тэрбум, хууль сахиулах салбарт 19.5 хувь буюу 4.5 тэрбум, эрчим хүчний салбарт 16 хувь буюу 3.7 тэрбум, хөдөө аж ахуйн салбарт 10.4 хувь буюу 2.4 тэрбум төгрөгийн төсөл хөтөлбөр хэрэгжиж байна. Шинээр батлагдаж эрх шилжсэн 1 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалт зарласан боловч шаардлага хангасан оролцогч оролцоогүй тул үнэлгээний хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу шууд гэрээ байгуулжээ. Засгийн газрын 2021 оны 397 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарцуулагдаагүй үлдэгдэл 1.6 тэрбум төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна. Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас өмнөх онд “Улсын төвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн аудитаар Захиалагч буюу аймгийн Засаг даргын тамгын газарт 4 зөвлөмж, 1.6 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 233.8 сая төгрөгийн 2 албан шаардлага өгсөн бөгөөд аудитаар тэдгээрийн хэрэгжилтийг дахин хянаж үзэхэд зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй хэвээр байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо үр нөлөөтэй байна уу?

Бүлэг 1

Хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд тавих хяналт, хариуцлагын тогтолцоо хангалтгүйгээс, төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсан хэвээр байна.

А.1. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, төслийн бэлэн байдал зэрэгт үнэлгээ хийхгүйгээр төлөвлөлт хийсээр байна.

Говьсүмбэр аймагт Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар 9 төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Батлагдсан төсөл, арга хэмжээг аймгийн хэмжээнд баримталж буй дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэж буй эсэхийг авч үзэхэд Хууль зүй дотоод хэргийн сайдын багцад батлагдсан “Цагдаагийн хэлтсийн барилга”, Улсын Ерөнхий Прокурорын багцад батлагдсан “Прокурорын газрын барилга”-ын ажлууд нь аймгийн дунд хугацаанд баримтлах бодлогын баримт бичгүүдтэй нийцээгүй бөгөөд салбарын ТЕЗ-ийн бодлогод тусгасан байна.¹

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд Говьсүмбэр аймагт шинээр 6,631.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ, өмнөх оноос дамжсан 16,483.2 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ батлагдсан байна.

Шинээр батлагдсан төсөл, арга хэмжээнээс Соёлын сайдын багцад батлагдсан “Дуу бүжгийн Боржигин чуулгын барилга” аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслэсэн бөгөөд ХХААҮС-ын багцад батлагдсан 200.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Шинэ хөдөө” төсөл, ХЗДХС-ын багцад батлагдсан “Цагдаагийн хэлтсийн барилга” нь салбарын ТЕЗ-ийн бодлогоор жагсаалтад батлагджээ.

Говьсүмбэр аймгийн ТЕЗ-аас Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд тусгаж хэрэгжүүлэхээр санал хүргүүлсэн төсөл, арга хэмжээг ТЕЗ-даар харуулбал:

Хүснэгт №1

(сая төгрөг)

№	Санал хүргүүлсэн ТЕЗ	2021 онд шинээр хэрэгжүүлэхээр санал хүргүүлсэн ТАХ тоо	Төлөвлөсөн төсөвт өртөг	2021 онд шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан ТАХ-ний тоо	Хуулиар батлагдсан төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн	Үүнээс: аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслэн	
							Төсөл арга хэмжээний тоо	Хүргүүлсэн санал болон батлагдсан төсөвт өртгийн зөрүү
1	БХБС	10	8,406.8					
2	ЭХС	1	325.8					
3	ЭМС	1	1,900.0					
4	ЗТХС	1	1,555.0					
5	БСШУС	15	20,914.5					
6	СоС	1	5,323.0	1	3,500.0	1,134.0	1	(1,823.0)
7	БОАЖС	2	487.9	-	-	-	-	-
8	ШС	1	800.0	0	-	-	0	-
9	ХХААХҮС			1	200.0	200.0	0	-
10	ХЗДХС			1	2,931.0	1,465.5	0	-
	Нийт	32	39,712.9	3	6,631.0	2,799.5	1	(1,823.0)

(Эх сурвалж: PublicInvestment.mn болон аймгийн ХОХБТХ-ийн мэдээ)

¹ Дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралт №1-ээс үзнэ үү.

Говьсүмбэр аймгийн ТЕЗ нь дээрх 32 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох ажлын хэсгийг байгуулж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, төслийн бэлэн байдал зэрэгт үнэлгээ хийхгүйгээр хөрөнгө оруулалтын саналын жагсаалтыг бэлтгэсэн байна. Хүргүүлсэн саналын 16.69% хувь нь батлагдсан нь хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд орон нутгийн хэрэгцээ шаардлагыг анхаарч үздэггүй, мөн төлөвлөлтийн шаардлагыг бүрэн хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөхгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2², 3.3³, 3.5⁴, 3.8⁵ дахь заалтуудыг зөрчсөн байна.

Өмнөх аудитаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын саналыг үнэлж, эрэмбэлэх тухай зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

А.2 Барилга байгууламжийн зураг төслийг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн байна.

2021 онд шинээр хэрэгжихээр батлагдсан “Дуу бүжгийн Боржигин чуулгын барилга”-ын ажил, он дамжсан 4 ажлын зураг төсөл, төсвийг орон нутгийн хэрэгцээ шаардлага, газрын зөвшөөрөл, инженер геологийн дүгнэлт болон холбогдох техникийн нөхцөл, ажлын даалгаврын дагуу иж бүрэн гүйцэтгэсэн байна. (Дэлгэрэнгүйг судалгааны маягт №1-аас үзнэ үү)

Шинээр эрх шилжин хэрэгжсэн “Дуу бүжгийн Боржигин чуулгын барилга”-ын ажлын зураг төсөл, төсвийг “Ориент Плюс” ХХК гүйцэтгэсэн бөгөөд ЗТ-1.2.1 тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй хуулийн этгээд байна.

Уг ажлын зураг төслийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 25.0 сая төгрөгийн хөрөнгөөр шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн бөгөөд ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

Тус ажлын зураг төсөл, төсөв нь Барилгын хөгжлийн төвийн 2021 оны 02 сарын 26-ны өдрийн 0147/2021 дугаартай магадлалын нэгтгэсэн дүгнэлт, экспертээр хянагдсан ба төсөвт өртгийг 7,609.7 сая төгрөгөөр баталгаажуулсан байна. (Хавсралт №2-аас зураг төсвийн гүйцэтгэгч болон тусгай зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацаа, олгосон санхүүжилтийг дэлгэрэнгүй үзнэ үү)

А.3 Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.

2021 онд шинээр хэрэгжих 9 төсөл, арга хэмжээнээс Шивээговь сумын 3 дугаар сургууль, Цагдаагийн хэлтсийн барилга, Прокурорын газрын барилга, Шинэ хөдөө төслүүд нь эрх шилжээгүй тул баримт материалууд аудитад хамрагдаагүй бөгөөд бусад хамрагдсан төсөл, арга хэмжээнүүд аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслэсэн, хэрэгцээ шаардлага, хүчин чадал нь орон нутгийн онцлогт тохирсон байна.

Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль, Соёлын сайдын багцад “Монгол соёл-Монгол Хүмүүн” хөтөлбөрийг 3,500.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан боловч тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөвт буцаан татагдсан.

Хөрөнгө оруулалтын ажлын төсөвлөлттэй холбоотой дараах зөрчил илэрлээ.

1. Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд “Дуу бүжгийн боржигин чуулгын барилга”-н ажлыг санхүүжүүлэхээр 3,500.0 сая төгрөг баталсан боловч уг ажлын зураг

² Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж, эсхүл мэргэжилтэн нь төслийг энэ журамд заасан тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу судлан шинжилж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол төслийн бэлэн байдлыг үнэлж, эрэмбэлэх ажлыг зохион байгуулна.

³ Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж, эсхүл мэргэжилтэн нь энэхүү чиг үүргийн хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

⁴ Ажлын хэсэг нь холбогдох аргачлалд заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд тухайн төслийг хэрэгжүүлэхэд үүсэж болох эрсдэлийн олон талт хүчин зүйлийг үнэлж хэлэлцэх, түүнийг бууруулах шийдлийг тодорхойлох, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх чиглэл баримтлан ажиллана.

⁵ Энэхүү аргачлалын дагуу Аймаг, нийслэлийн засаг дарга нь төслийн саналыг тооцоо судалгаанд үндэслэн холбогдох аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн сонгосны үндсэн дээр Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

төсөв 2021 оны 02 сарын 26-нд буюу хууль батлагдсаны дараа 7,609.8 сая төгрөгийн өртөгтэйгөөр магадлалаар баталгаажсан.

2. Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуульд БСШУСС-дын багцад батлагдсан “Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга” нь шилжих хөрөнгө оруулалт боловч Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд санхүүжилт батлагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁶, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.4.4⁷, 7 дугаар зүйлийн 7.2.2⁸, 8 дугаар зүйлийн 8.1.1⁹-т заасныг тус тус зөрчсөн тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар 23,114.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий тухайн жилд 8,571.9 сая төгрөгөөр санхүүжих 9 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна.

2021 онд 18,295.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар батлаагүй байна. Үүнд:

Төсвийн тухай хуулиар тухайн жилд санхүүжүүлж байгаа эрх шилжсэн төсөл, арга хэмжээнд хуваарилагдсан санхүүжилтийн дүнг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2

(сая төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг	2021 он тухайн жилд ногдох	Тэнцүү хуваасан дүн	Зөрүү
1	2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2019-2021	3,437.3	812.0	1,145.8	(333.8)
2	Сургуулийн барилга, 640 суудал /Говьсүмбэр, Сүмбэр сум, 2 дугаар сургууль/	2019-2021	5,629.4	1,500.0	1,876.5	(376.5)
3	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2019-2022	1,619.2	-	404.8	(404.8)
4	Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/	2020-2023	7,609.8	1,134.0	1,902.5	(768.5)
Нийт			18,295.7	3,446.0	5,329.5	(1,883.5)

(Эх сурвалж: Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хууль)

Хөрөнгө оруулалтын ажлыг богино хугацаанд гүйцэтгэх нь эдийн засгийн хувьд үр ашигтай боловч 2,000.0-7,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын санхүүжилтийг 2-4 жилийн хугацаанд харилцан адилгүй дүнгээр хуваан олгож байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5¹⁰-т заасныг зөрчсөн байна.

Говьсүмбэр аймгийн ТЕЗ бөгөөд Засаг дарга нь хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулаагүй байна.

⁶ 29.4-Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁷ 6.4.4-Мэргэжлийн байгууллагын дүгнэлт

⁸ 7.2.2-Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх

⁹ 8.1.1-Шилжих буюу хэрэгжүүлж буй төсөл

¹⁰ 29.3.5-Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах.

Б. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байна уу?

Бүлэг 2 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт үр нөлөөгүй, хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг ашиглахгүй байгаа нь төсвийн хөрөнгө үр дүнгүй зарцуулагдаж байгааг харуулж байна.

Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд жил бүр гомдол санал гарсаар байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд Говьсүмбэр аймагт шинээр хэрэгжих 3 төсөл, арга хэмжээнээс Соёлын сайдын багцад батлагдсан “Дуу бүжгийн Боржигин чуулгын барилга”-ын ажил, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын багцад “Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөр”-ийн задаргаанд тусгагдсан арга хэмжээг аймгийн Засаг даргад хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар эрх шилжүүлсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Дуу бүжгийн Боржигин чуулгын барилга”-ын ажлыг нээлттэй тендер шалгаруулалт, “Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөр”-ийг 2 багц болгон харьцуулалтын аргаар тус тус тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 3,550.6 сая төгрөгийн гэрээ байгуулах эрх олгожээ. Үүнд:

- 3,500.0 сая төгрөгийн “Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга”-ын ажлыг шууд гэрээ байгуулах
- 50.6 сая төгрөгийн “Говьсүмбэр аймгийн цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах” ажилд Багц 1-т “Батбадрах дэлгэр” ХХК, Багц 2-т “Жавхлан-Аривжих” ХХК-тай гэрээ байгуулах

“Дуу бүжгийн Боржигин чуулгын барилга”-ын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад оролцогч компаниас захиалагч, үнэлгээний хорооны шийдвэрийг хууль бус гэж үзэн Сангийн яаманд гомдол гаргасан бөгөөд үүнээс шалтгаалан цаг хугацаа алдаж төсөл, арга хэмжээ тайланд онд бүрэн буюу зорилтот түвшинд хүрч хэрэгжих боломжгүй болсон байна.

Тус ажлын тендерийн баримт бичигт тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа болон тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн (5.3б) мэдээллийг зөрүүтэй бэлтгэсэн нь дээрх гомдол гарах шалтгаан болсон байна.

Цаашид Тендерийн баримт бичигт хоёрдмол утгатай буюу зөрүүтэй шаардлага тусгахгүй байх шаардлагатай байна.

Тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулж, төрийн худалдан авах ажиллагааны цахим системд тухай бүр нийтлэн ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангажээ.

Орон нутгийн өмчийн газар нь Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2021 оны худалдан авах ажиллагааны тайланг хугацаанд нь Сангийн яаманд тайлагнасан боловч ТЕЗ-ийн дотоод аудитын нэгжээр хянагдаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж санхүүжилтийг нь олгосон 3 төсөл, арга хэмжээний мэдээллийг аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс нь шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Үүнд:

1. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт
2. Таван сая төгрөгөөс дээш санхүүжилт авсан гүйцэтгэгчийн нэр хаяг, төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээлэл

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4¹¹, 6.4.4¹²-т заасныг зөрчсөн тул зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

Б.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг хангуулах тал дээр үр дүнтэй ажиллаж чадаагүй байна.

Говьсүмбэр аймагт эрх шилжсэн шинээр болон шилжих хөрөнгө оруулалтын 5 төсөл, арга хэмжээний дундаж гүйцэтгэл 65.6 хувьтай байна.

Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хувийг харуулбал:

Хүснэгт 3

№	Гүйцэтгэгч	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэлийн хувь
1	Санжат ХХК	2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж /Говьсүмбэр, Сүмбэр сум/	100.00
2	Идэр чандмань ХХК	Сургуулийн барилга, 640 суудал /Говьсүмбэр, Сүмбэр сум, 2 дугаар сургууль/	90.34
3	Түмэн алт ХХК	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум/	79.00
4	Хан-аттрибут ХХК	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	32.00
5	Хөшиг-Уул ХХК	Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/	26.70
Нийт			65.61

(Эх сурвалж: аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн мэдээ)

Гүйцэтгэгч компаниуд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөл, төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэж байгаа боловч ажлын гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- 2,149.9 сая төгрөгийн өртөгтэй батлагдсан “Хан аттрибут” ХХК-ийн гүйцэтгэж буй “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга”, 1,619.2 сая төгрөгийн өртөгтэй батлагдсан “Түмэн алт” ХХК-ийн гүйцэтгэж буй “Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга”-ын ажлууд 2019-2022 оны хугацаанд 4 жил үргэлжилж байгаа бөгөөд өнөөдрийг хүртэл дуусаагүй.
- “Идэрчандмань” ХХК-ийн гүйцэтгэж буй “Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн барилга”-ын 1 давхрын шал болон дулааны сувгийн хэсгүүдэд суулт өгсөн, анги танхимын гэрэлтүүлгийн шийдлүүд зохимжгүй хийгдсэн тул захиалагчийн хяналт болон зохиогч зөвшилцөж асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь Барилгын хөгжлийн төвтэй байгуулсан гэрээгээр барилга, байгууламжийн захиалагчийн хяналтын чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлж байна.

Аймгийн ЗДТГ нь Говьсүмбэр аймагт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай гэрээ байгуулж ажиллажээ.

Тус гэрээнд зааснаар 2021 онд эрх шилжин шинээр хэрэгжих “Дуу бүжгийн Боржигин чуулгын барилгын ажил”, он дамжин хэрэгжих 4 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг тавихаар тусгасан байна.

Уг гэрээний үүргийн дагуу захиалагчийн хяналтыг тавьж, үе шатны ажлыг хугацаанд нь бүрэн баталгаажуулж, үр дүнг тооцож ажилласан байна.

Зохиогчийн хяналт хэрэгжүүлж буй байгууллага, төсөл арга хэмжээг харуулбал:

¹¹6.2.4 хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт

¹² 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

№	ТАХ-ний нэр	Зохиогчийн хяналт хэрэгжүүлэх байгууллагын нэр	Зохиогчтой байгуулсан гэрээний дүн
1	Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн барилга угсралтын ажил	"ЭН ЭЙ ИИ" ХХК	48.2
2	Сүмбэр сумын 2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж суурилуулах ажил	"Урбан Девелопмент Консалтинг Групп" ХХК	26.3
3	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга угсралтын ажил	"Баяр мега сервис" ХХК	3.5
4	Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга угсралтын ажил	"Нарлаг хөхий" ХХК	18.4
5	Дуу бүжгийн боржигин чуулгын барилгын ажил	"Гандирс од" ХХК	13.0
6		"Ориент плюс" ХХК	30.1
Нийт			139.5

(Эх сурвалж: Захиалагч зохиогчтой байгуулсан гэрээ)

2019-2021 оны хооронд он дамжин болон шинээр хэрэгжиж буй 5 төсөл, арга хэмжээнээс "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилга"-ын ажилд зохиогчийн хяналт хэрэгжүүлж буй "Нарлаг хөхий" ХХК, "Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн барилга"-ын ажилд зохиогчийн хяналт хэрэгжүүлж буй "Гандирс од" ХХК-иуд захиалагчтай байгуулсан гэрээний дагуу хяналт хэрэгжүүлээгүй байна.

2021 онд ашиглалтад хүлээн авсан "Сүмбэр сумын 2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж суурилуулах ажил"-ыг хүлээн авах комиссыг аймгийн Засаг даргын 2021 оны А/259 тоот захирамжаар байгуулсан бөгөөд 2021 оны 11 сарын 03-ны өдөр хүлээн авсан байна.

Тус хөрөнгө оруулалтын ажилд нэмэлтээр хийгдсэн худгийн насос, төмөргүйжүүлэх төхөөрөмжийн бодис болон 1000м³ усан сангийн сорох хоолойн түвшинг доошлуулах зэрэг ажлууд хийгдээгүй бөгөөд гүйцэтгэгч "Санжат" ХХК 2022 оны 6 дугаар сарын 30-ны дотор нийлүүлэх гүйцэтгэлийн баталгаа гаргаж өгсөн байна.

Говьсүмбэр аймагт Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтаар хийсэн "Орон сууцны тоглоомын талбайн тохижилт"-ийн ажлыг улсын комисс ажиллан үүрэг даалгавар өгсөн боловч техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээнд тусгасан хөгжимтэй усан оргилуур хийгдээгүй, гэрэлтүүлгийн шийдэл оновчгүйгээс салхинд хийсэж эвдэрсэн, усан сангууд цөмөрч суулт өгсөн байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.8¹³-т заасныг зөрчсөн тул зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хийгдсэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн ордны зураг төсвийг 20.0 сая, Ус зайлуулах системийн зураг төсвийг 15.0 сая төгрөгөөр хийлгэн 2021 оны улсын төсөвт хөрөнгө оруулалтын ажилд ашиглах санал хүргүүлсэн боловч батлагдаагүй байна.

Б.3 Хяналтын тогтолцоо оновчгүйгээс төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналт үр дүнгүй байна.

Захиалагч нь 2021 онд шинээр эрх шилжиж хэрэгжсэн 1 ажил, өмнөх оноос дамжсан 4 нийт, 5 ажилд Барилгын тухай хуульд заасны дагуу зохиогч ба захиалагчийн хяналтын гэрээ байгуулсан байна.

Уг гэрээний дагуу зохиогчийн хяналтын зардалд 139.5 сая төгрөг олгохоос тайлант хугацаанд 34.6 сая, нийт 101.7 сая төгрөг, захиалагчийн хяналтын зардалд 271.8 сая төгрөг олгохоос тайлант хугацаанд 46.3 сая, нийт 192.3 төгрөгийг тус тус олгосон байна.

¹³ 40.1.8 "Барилга байгууламжийн ашиглалтыг зүгшрүүлэх, тохируулах хугацаанд өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гарсан хохирлыг хариуцах","

Зарим төсөл, арга хэмжээнд захиалагч болон зохиогчтой байгуулсан гэрээний үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй, үе шатны хяналтыг хугацаанд нь хэрэгжүүлээгүй, хяналтын зардлыг үнэн зөв тооцож олгоогүй байна. Үүнд:

1. “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилгын ажил”-д зохиогч “Нарлаг Хүхий” ХХК нь 2019 оноос хойш зохиогчийн хяналт огт хэрэгжүүлээгүй. 2021 онд улсын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт буцаан татуулахгүй гэсэн шалтгаанаар бодит гүйцэтгэлээс илүү гүйцэтгэл баталгаажуулан Сангийн яамнаас 700.0 сая төгрөгийн санхүүжилт авч барьцаа дансанд байршуулсан.
2. “Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга”-ыг гүйцэтгэгч “Түмэн алт” ХХК-д барилгын зургийг зохиогч “Гандирс од” ХХК зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээ байгуулсан боловч барилгын ажил 79 хувийн гүйцэтгэлтэй болсон байхад хэрхэн хяналт хэрэгжүүлсэн нь тодорхойгүй, зохиогчийн хяналтын тэмдэглэл хийж баталгаажуулаагүй.
3. “Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн барилга”-ын ажлын зохиогчийн хяналтаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт хангалтгүй.
4. “Сүмбэр сумын 2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж суурилуулах ажил”-д зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн “Урбан Девелопмент Консалтинг Групп” ХХК-д гэрээний дүнгээс 6.4 сая, захиалагчийн хяналтын зардал 5.7 сая төгрөгийг тус тус илүү олгосон.

Энэ нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5¹⁴, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8 дугаар зүйлийн 8.5¹⁵, Барилга хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Барилгын ажилд зураг төсөв зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 4.1.6¹⁶, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт, тайлагналтын журам”-ын 15 дугаар зүйлийн 15.3¹⁷, 15.6¹⁸-д заасныг тус тус зөрчсөн тул зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Говьсүмбэр аймгийн ТЭЗ-д эрх шилжсэн шинээр болон шилжих хөрөнгө оруулалтын 4 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид 4,146.0 сая төгрөгийг олгохоос 2,562.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, 1,569.4 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн байна.

Эрх шилжсэн төсөл, арга хэмжээнд олгосон санхүүжилтийг харуулбал:

Хүснэгт №5

(сая төгрөг)

№	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр	Хуулиар тухайн жилд санхүүжүүлэхээр батлагдсан дүн	2021 онд олгосон санхүүжилт	Зөрүү	Тайлбар
Шилжих хөрөнгө оруулалт					
1	2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн	812.00	798.35	13.65	

¹⁴ 37.1.5.Барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах;

¹⁵ 8.5. Хөрөнгө оруулалтын зардлын гүйлгээг гүйцэтгэхдээ дансны хуулгыг үндэслэн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний төлбөрийн нөхцөлд заасан барьцаа, техник хяналт болон гүйцэтгэгчийн холбогдох дансанд тус тус шилжүүлнэ.

¹⁶ 4.1.6.барилгын ажил гүйцэтгэх явцад зохиогчийн хяналт гүйцэтгэгчээс өгсөн үүрэг, даалгавар, “Зохиогчийн хяналтын тэмдэглэл”-д /Хавсралт №1/ бичигдсэн зөвлөмж, шаардлагын биелэлтийг хянах;

¹⁷ 15.3 Захиалагч нь барилга байгууламжийн ажлын үе шат бүрт зохиогчоор хяналт тавьж, дүгнэлт гаргуулна.

¹⁸ 15.6 Захиалагч байгууллага төсвийн хөрөнгөөр баригдаж буй барилга, их засварын ажил бүрийг биечлэн хянаж, шалгах үүрэг бүхий хяналтын инженер, хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх компанийг ажиллуулах бөгөөд хяналтын инженер, хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлж буй компани нь хяналт хийсэн тухай бүр тэмдэглэл үйлдэж, гүйцэтгэгч байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар, түүний биелэлтийн талаар тэмдэглэж ажлын гүйцэтгэлд хавсаргаж, их засварын ажил дууссаны дараа санхүүжилтийн материалын хамт захиалагчийн архивд хадгалуулна.

Улсын төсвийн 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

	эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж /Говьсүмбэр, Сүмбэр сум/				
2	Сургуулийн барилга, 640 суудал /Говьсүмбэр, Сүмбэр сум, 2 дугаар сургууль/	1,500.00	830.56	669.44	669.4 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулсан.
3	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Боржигон-эко төсөл/	700.00	-	700.00	700.0 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулсан.
Шинээр батлагдсан хөрөнгө оруулалт					
1	Дуу бүжгийн боржигин чуулгын барилга /Говьсүмбэр/	1,134.00	934.00	200.00	200.0 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулсан.
Нийт		4,146.0	2,562.9	1,583.10	

(Эх сурвалж: Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хууль)

Дээрх хөрөнгө оруулалтын ажлуудаас “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилга”-ын ажлыг гүйцэтгэгч “Хан атрибут” ХХК-ийн ажлын гүйцэтгэлийг бодитоор баталгаажуулаагүй байна.

Аймгийн ТЕЗ-ийн дотоод хяналт, аудитын албанаас тус аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд хяналт тавьж ажиллаагүй байна.

Б.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор Засгийн газраас гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Засгийн газрын 2019 оны 430, 2020 оны 253, 2021 оны 397 дугаар тогтоолын дагуу 2019-2021 оны хооронд улсын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл санхүүжилт болох 3,308.0 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна.

График №1



(Эх сурвалж: Барьцаа дансны хуулга, АЗД-ын 2021 оны А/371 тоот захирамж)

2019 онд 7 төсөл, арга хэмжээний 1,698.7 сая, 2020 онд 1 төсөл, арга хэмжээний 39.9 сая, 2021 онд 3 төсөл, арга хэмжээний 1,569.4 сая төгрөгийг улсын төсвөөс эрх шилжсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд үлдэгдлээр байршуулжээ.

Барьцаа дансанд байршуулсан санхүүжилттэй холбоотой дараах зөрчил илэрсэн.

Үүнд:

- “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилга”-ын ажлын гүйцэтгэлийг бодит гүйцэтгэлээс илүү баталгаажуулж, 700.0 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулсан.

Б.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцохгүй байна.

2021 онд “2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж”-ийн ажлыг шинээр ашиглалтад хүлээн

Улсын төсвийн 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн авсан бөгөөд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 46 дугаар тогтоолын дагуу “УС-ДУ” ОНӨААТҮГ-т бүртгэх шийдвэр гарч, ашиглагч байгууллага данс бүртгэлд бүртгэсэн байна.

Нэмэлтээр хийсэн гүний худгийн насос, төмөргүйжүүлэх төхөөрөмжийн бодис зэрэг нь ковид-19 цар тахлын улмаас тогтоосон хилийн хоригт орж хугацаандаа нийлүүлэх боломжгүй болсон тул гүйцэтгэгч 2022 оны 06 сарын 30-ны дотор нийлүүлэх баталгаа гаргажээ.

2019, 2021 оны Монгол Улсын Төсвийн тухай хуульд батлагдсан “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн тоног төхөөрөмж”, “Шинэ хөдөө” төслийн 972.5 сая төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмжийг хүчин чадал, зориулалтын дагуу ашиглаагүй, хадгалалт хамгаалалтын байдал хангалтгүй байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн боловч ашиглалтгүй байгаа хөрөнгө оруулалтын ажлыг харуулбал:

Хүснэгт №6

(сая төгрөг)

Он	Төслийн нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Ашиглалтгүй байгаа хөрөнгийн дүн	Эзлэх хувь
2018	“Сүмбэр сумын төвийн 3 хос гол магистраль шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажил”	50.0	49.9	49.9	100%
2019	ЖДҮ-ийг дэмжих төвийн тоног төхөөрөмж	800.0	780.2	651.7	84%
2019	Шинэ хөдөө төсөл	500.0	494.1	71.1	14%
2021	Шинэ хөдөө төсөл	200.0	199.8	199.8	100%
Нийт		1,550.00	1,524.00	972.5	75%

Цаашид барилгын ажил нь удаашралтай байгаа “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилга”-ын ажлыг дуусгах, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаж, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд батлагдан он дамжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт ороогүй байна.

Өмнөх онуудын улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар дээрх ажлуудтай холбоотой өгсөн 2 зөвлөмж хэрэгжээгүй байна. Тухайлбал:

1. Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө сэдэвт аудитаар өгсөн “Сүмбэр сумын төвийн 3 хос гол магистраль шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажил”-ыг хүчин чадлаар ашиглах
2. Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө сэдэвт аудитаар өгсөн “Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг батлагдсан аргачлал, заавар журмын дагуу санал бэлтгэж, үнэлж эрэмбэлэх”

Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул МУЕА-ын 2020 оны А95 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10¹⁹-т заасныг зөрчсөн тул зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.


Орон нутагт хэрэгжиж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтууд нь ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд бус нийгмийн салбарт чиглэгджээ.

¹⁹ 4.2.1.10-Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол

Говьсүмбэр аймагт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг салбараар нь ангилж үзвэл боловсрол, соёлын салбарт нийт төсөвт өртгийн буюу 54.1 хувь буюу 12,429.4 сая төгрөг хуваарилагдаж зарцуулсан байна.

Хэрэгжиж буй төсөл арга хэмжээг салбараар нь авч үзвэл:

Дүрслэл №1



Иймд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг боловсруулахдаа эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч ажиллах шаардлагатай байна.

2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дэд бүтцийн салбарт 3,757.1 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ батлагджээ.

Говьсүмбэр аймгийн цэвэр усны усан сан 1500м³-ээр нэмэгдэж, гэр хорооллын айл өрхүүдэд үйлчлэх төвийн шугамд холбогдсон 6 ухаалаг худаг, 8000м урт шугам хоолой, цахилгаан хангамж, газар доорх гүний худаг, ус цэвэршүүлэх төхөөрөмж, шинээр баригдах дулааны станцтай холбогдох шугам сүлжээ, шинэ суурьшлын бүсэд цахилгааны эх үүсвэр татагдаж улмаар хөрөнгө оруулалтын нөлөөгөөр “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын цэвэр ус түгээх хүчин чадал нь нэмэгдсэн байна.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 4,248.7 сая төгрөгийн 9, зөрчил илрүүлж зөрчлийг арилгах болон давтан гаргахгүй байх 3,326.1 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 922.6 сая төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-1

1. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, төслийн бэлэн байдал зэрэгт үнэлгээ хийхгүйгээр төлөвлөлт хийсээр байна.
2. Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилт хангалтгүй байна

Бүлэг-2

1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд жил бүр гомдол санал гарсаар байна.
2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг хангуулах тал дээр үр дүнтэй ажиллаж чадаагүй байна.
3. Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд ТЕЗ-аас дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор Засгийн газраас гарсан шийдвэр үр нөлөөгүй байна.
5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцохгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.
Үүнд:

Аймгийн Засаг даргад:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод аудитын албаар дотоод хяналтыг хэрэгжүүлэх
2. Худалдан авах ажиллагааны тайланд дотоод аудитын албаар дотоод хяналт хэрэгжүүлэх
3. "Шинэ хөдөө", "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв"-ийн тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглах, төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарч ажиллах

Аймгийн Орон нутгийн өмчийн газарт:

4. Тендерийн баримт бичигт хоёрдмол утгатай буюу зөрүүтэй шаардлага тусгахгүй байх, жишиг маягтын дагуу баримт бичгийг боловсруулах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас/Факс: (976) 7054 3118,
И-мэйл: zdtg.gsa@gmail.com, Вэбсайт: www.govisumber.gov.mn

2022.04.26 № 01/572
танай 2022.04.25 -ны № 150 -т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд тусгах
санал байхгүй болно.

ДАРГА



Д.СОДНОМ

А/а Б. Доржпалма
Тайланг нэгдсэн
баталгаануудыг,
холбогдох байгуул-
лагыг хураарх
Внуф
17.06

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР:

Тайлангийн төсөлтэй холбоотой санал ирээгүй тул аудитын тайланг эцэслэн батлуулсан.

Орон нутгийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	ТЕЗ-ийн нэр	Аймгийн Засаг даргын 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөр	Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл
1	XII.1.4	2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж /Говьсүмбэр, Сүмбэр сум/	БХБС	3.7.9.12	3.7.9.12
2	XIII.1.1.58	Сургуулийн барилга, 640 суудал /Говьсүмбэр, Сүмбэр сум, 2 дугаар сургууль/	БСШУС С	2.3.5.7	2.3.4.7
3	XIII.1.1.46	Сургуулийн барилга, 320 суудал /Говьсүмбэр, Шивээговь сум, 3 дугаар сургууль/	БСШУС С	2.3.5.7	2.3.4.7
4	X.4.1.4	Цагдаагийн хэлтсийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	ХЗДХС	Нийцээгүй	Нийцээгүй
5	XVII.1.2	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга	ХХААХҮ С	3.3.8.21	3.3.8.21
6	XVIII.1.9	Сумын өмчлөлд олгох 6 кВт-ын шугам, КТПН байгуулж, цахилгааны эх үүсвэр /Говьсүмбэр, Сүмбэр сум/	ЭХС	3.5.1.1	3.5.1.1
7	XXII.1.2	Прокурорын газрын барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	УЕП	Нийцээгүй	Нийцээгүй
8	XIV.1.45	Дуу бүжгийн “Боржигин” чуулгын барилга /Говьсүмбэр/	СС	2.6.2.2	2.6.2.2
9	XVII.3.3	Шинэ хөдөө төсөл /Говьсүмбэр	ХХААХҮ С	3.3.8.24	3.3.8.24

(Эх сурвалж: Говьсүмбэр аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичиг)

Зураг төслийн гүйцэтгэгч байгууллагуудын тусгай зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацаа

№	ТАХ нэр	Зураг төслийн гүйцэтгэгч	Тусгай зөвшөөрлийн төрөл	Магадлалын дүгнэлт	Тусгай зөвшөөрлийн дуусах хугацаа /2021 оны байдлаар/
1	2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж /Говьсүмбэр, Сүмбэр сум/ Сургуулийн барилга, 640 суудал /Говьсүмбэр, Сүмбэр сум, 2 дугаар сургууль/ Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум, 5 дугаар цэцэрлэг/ Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Боржигон-эко төсөл/ Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/	Урбон девелопмент консалтинг групп ХХК	ЗТ-1.1.1, ЗТ- 1.1.2, ЗТ-3.1, ЗТ-3.2, ЗТ-3.4, ЗТ-3.5, ЗТ-3.6, ЗТ-4.1, ЗТ-4.4, ЗТ-4.5, ЗТ-5.4, ЗТ-5.5, ЗТ-6.1, ЗТ-6.2, ЗТ-6.3, ЗТ-6.4, ЗТ-7.1, ЗТ-7.2, ЗТ-7.3, ЗТ-7.4, ЗТ-8.1	2018.10.24 1444/2018	5/6/2026
2		Эй Эн И И ХХК	ЗТ-1.1.2, ЗТ- 1.2.2, ЗТ-1.2.4, ЗТ-1.2.5, ЗТ- 1.3.2	2018.07.23 БД- 0875/2018	9/21/2022
3		Гандирс Од ХХК	ЗТ-1.2.2, ЗТ- 1.1.1, ЗТ-1.1.2	2015.08.18 846/2015	5/17/2022
4		Нарлаг Хөхий ХХК	ЗТ-1.2.1, ЗТ- 1.2.4, ЗТ-1.2.5, ЗТ-1.2.6	2018.08.28 1097/2018	12/14/2022
5		Ориент Плюс ХХК	ЗТ-1.2.1	2021.02.26 0147/2021	6/16/2021

(Эх сурвалж: Mscud.gov.mn Mnca.mn)

Зохиогчийн хяналтын гэрээний дүн, гүйцэтгэл

№	ТАХ-ний нэр	Зохиогчийн хяналт хэрэгжүүлэх байгууллагын нэр	Зохиогч байгуулсан гэрээний дүн	Олгосон			Нийт	Үлдэгдэл
				2019	2020	2021		
1	Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн барилга угсралтын ажил	"ЭН ЭЙ ИИ" ХХК	48.2	16.5	18.8	11.6	46.9	1.3
2	Сүмбэр сумын 2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж суурилуулах ажил	"Урбан Девелопмент Консалтинг Групп" ХХК	26.3	9.3	14.0	9.4	32.7	-6.4
		"Баяр мега сервис" ХХК	3.5			3.5	3.5	-
3	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга угсралтын ажил	"Нарлаг хүхий" ХХК	18.4	8.5			8.5	9.9
4	Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга угсралтын ажил	"Гандирс од" ХХК	13.0	-			-	13.0
5	Дуу бүжгийн боржигин чуулгын барилгын ажил	"Ориент плюс" ХХК	30.1			10.0	10.0	20.1
Нийт			139.5	34.3	32.8	34.6	101.7	37.9

(Эх сурвалж: Зохиогчийн хяналтын гэрээ)

Захиалагчийн хяналтын гэрээний дүн, гүйцэтгэл

№	ТАХ-ний нэр	Гэрээнд тусгагдсан зардлын дүн	ГХБХБГ			АЗДТГ			Нийт олгосон	Үлдэгдэл
			2019	2020	2021	2019	2020	2021		
1	2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж /Говьсүмбэр, Сүмбэр сум/	52.5	13.0	19.6	8.1	5.6	8.4	3.5	58.2	-5.7
2	Сургуулийн барилга, 640 суудал /Говьсүмбэр, Сүмбэр сум, 2 дугаар сургууль/	96.3	9.5	35.4	10.3	4.1	15.2	4.4	78.9	17.4
3	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум, 5 дугаар цэцэрлэг/	26.0	-	18.2		-	-		18.2	7.8
4	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Боржигон-эко төсөл/	36.7	11.9	-		5.1	-		17.0	19.7
5	Дуу бүжгийн боржигин чуулгын барилгын ажил	60.3			14.0			6.0	20.0	40.2
Нийт		271.8	34.4	73.2	32.4	14.8	23.6	13.9	192.3	79.5

(Эх сурвалж: Захиалагчийн хяналтын гэрээ)